

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/28

Сүмбэр сум

“Монголын хүүхдүүд” хүүхдийн урлагийн
их наадамд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.5, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн 3.2 зорилт 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын хүүхдүүд” хүүхдийн урлагийн их наадмын төсвийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх ажлын хүрээнд “Монголын хүүхдүүд” хүүхдийн урлагийн их наадамд оролцох сурагчдын аюулгүй байдлыг хангахыг Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн /Э.Урантунгалаг/-д даалгасугай.

3. “Монголын хүүхдүүд” хүүхдийн урлагийн их наадамд зарцуулагдах 781 810 /Долоон зуун наян нэгэн мянга найман зуун арван/ төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансны бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Д.Оюунцэцэг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Ц.ОЮУНБИЛЭГ

Д:/Бичиг хэрэг /тушаал

421190044